



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ЦАГААН ШОНХОР ТӨААТУГ-ЫН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНД
ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: АХГ-2022/79/НА-СТА-ТӨА

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх аудитор
Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: Ц.Хосжаргал
Утас: 261885 Цахим хаяг: khosjargalts@audit.gov.mn
Ахлах аудитор: Б.Энхжин
Утас: 261740 Цахим хаяг: enkhjinb@audit.gov.mn
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Б энд С аудит ХХК
Захирал: Д.Дашхорлоо
Утас: 70114810 Цахим хаяг: audit_bc@yahoo.com

Улаанбаатар хот
2022 он

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан	5
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	7
2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл	8
3. Аудитын тайлан	9
3.1 Ерөнхий зүйл	9
3.2 Дотоод хяналт	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	9
3.4 Материаллаг байдал	9
4. Санхүүгийн тайлангийн тодруулга	10
4.1 Байгууллагын үйл ажилагаа	10
4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин	10
4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого	11
4.4. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл	12
5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	12
5.1 Шилэн дансны мэдээлэл	12
6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	13
7. Аудитын илрүүлэлт	14
7.1 Залруулсан алдаа	14
7.2 Төлбөрийн акт	14
7.3 Албан шаардлага	14
8. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	15

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТӨААТҮГ	Төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ХЗДХЯ	Хууль зүй дотоод хэргийн яам
ЦЕГ	Цагдаагийн ерөнхий газар



ЦАГААН ШОНХОР ТӨААТҮГ-ЫН
ДАРГА Н.МӨНХ-ОРГИЛ ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2022.03.15 № 07/582
танай _____-ны № _____-т

Хараат бус аудиторын тайлан

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Цагаан шонхор ТӨААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Цагаан шонхор ТӨААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудалд тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй зүйлсийг тодруулах ба тэдгээрийг аудитын хүрээнд нэгтгэсэн байдлаар авч үзсэн болно.

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2020 оны 640 дугаар тогтоолоор Цагаан шонхор ТӨААТҮГ-ын 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд нийт орлогыг 578.1 сая төгрөгөөр, нийт зардлыг 551.4 сая төгрөгөөр, үүнээс хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 25.0 сая төгрөгийг, ашгийг 26.7 сая төгрөг байхаар баталсан байна.

Гүйцэтгэлээр 424.8 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 605.6 сая төгрөгийн зардал гарган, 180.8 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Байгууллага 2 зорилтын хүрээнд 6 арга хэмжээг төлөвлөж, гүйцэтгэлээр 13.9 хувийн биелэлттэй гэж тайлагнасан байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

				/төгрөгөөр/	
Мөрийн дугаар	Үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31		
1	ХӨРӨНГӨ				
1.1	Эргэлтийн хөрөнгө				
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	6,140,782.70	180,528,144.86		
1.1.2	Дансны авлага	40,762,000.00	34,750,000.00		
1.1.6	Бараа материал	210,615,808.88	48,601,745.41		
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	257,518,591.58	263,879,890.27		
1.2	Эргэлтийн бус хөрөнгө				
1.2.1	Үндсэн хөрөнгө	270,814,898.83	250,242,571.42		
1.2.2	Биет бус хөрөнгө	77,460,940.00	77,392,190.00		
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	348,275,838.83	327,634,761.42		
1.3	Нийт хөрөнгийн дүн	605,794,430.41	591,514,651.69		
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ				
2.1	ӨР ТӨЛБӨР				
2.1.1	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР				
2.1.1.1	Дансны өглөг	22,888,050.00			
2.1.1.3	Татварын өр	11,030,008.59	427,029.94		
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	6,200,000.00	208,500,000.00		
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	40,118,058.59	208,927,029.94		
2.2	Өр төлбөрийн нийт дүн	40,118,058.59	208,927,029.94		
	ЭЗДИЙН ӨМЧ				
2.3	Өмч	59,469,098.00	59,469,098.00		
2.3.1	-төрийн	59,469,098.00	59,469,098.00		
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	201,226,713.00	201,226,713.00		
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	92,199,766.00	92,199,766.00		
2.3.9	Хуримтлагдсан ашиг	212,780,794.82	29,692,044.75		
2.3.11	Эздийн өмчийн дүн	565,676,371.82	382,587,621.75		
2.4	Өр төлбөр ба эздийн өмчийн дүн	605,794,430.41	591,514,651.69		

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

				/төгрөгөөр/	
Мөрийн дугаар	Үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31		
1	Борлуулалтын орлого (цэвэр)	800,766,450.00	421,915,000.00		
2	Борлуулалтын өртөг	342,270,183.86	375,001,573.92		
3	Нийт ашиг (алдагдал)	458,496,266.14	46,913,426.08		
4	Түрээсийн орлого				
5	Хүүний орлого	213,628.72			
6	Ногдол ашгийн орлого				
7	Эрхийн шимтгэлийн орлого				
8	Бусад орлого	3,163,600.00	2,870,352.16		
9	Борлуулалт, маркетингийн зардал				

АХГ-2022/79/НА-СТА-ТӨА

10	Ерөнхий ба удирдлагын зардал	433,786,175.54	228,816,488.84
11	Санхүүгийн зардал		
12	Бусад зардал	2,062,000.00	1,732,800.00
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	5,932.85	(1,049.47)
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)		
17	Бусад ашиг (алдагдал)		
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	26,031,252.17	(180,766,560.07)
19	Орлогын татварын зардал	2,809,325.22	-
20	Татварын дараахь ашиг (алдагдал)	23,221,926.95	(180,766,560.07)
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	23,221,926.95	(180,766,560.07)

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2019 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	59,469,098.00	201,226,713.00	92,199,766.00	198,068,867.87	550,964,444.87
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга					
Залруулсан үлдэгдэл	59,469,098.00	201,226,713.00	92,199,766.00	198,068,867.87	550,964,444.87
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				23,221,926.95	23,221,926.95
Зарласан ногдол ашиг				(8,510,000.00)	(8,510,000.00)
2020 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	59,469,098.00	201,226,713.00	92,199,766.00	212,780,794.82	565,676,371.82
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга					
Залруулсан үлдэгдэл	59,469,098.00	201,226,713.00	92,199,766.00	198,068,867.87	550,964,444.87
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				(180,766,560.07)	(180,766,560.07)
Зарласан ногдол ашиг				(2,322,190.00)	(2,322,190.00)
2021 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	59,469,098.00	201,226,713.00	92,199,766.00	29,692,044.75	382,587,621.75

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1.1	Мөнгөн орлогын дүн	790,789,966.85	695,369,170.00
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	766,204,450.00	663,977,000.00
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	2,155,584.00	992,170.00
1.1.6	Бусад мөнгөн орлого	22,429,932.85	30,400,000.00
1.2	Мөнгөн зарлагын дүн	843,432,693.16	499,442,167.31
1.2.1	Ажиллагчдад төлсөн	236,631,915.00	190,774,804.67
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	67,205,526.78	58,750,691.42
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	330,866,331.25	101,012,104.00
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	9,426,980.86	11,439,033.50
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	6,961,310.00	13,727,740.00
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	2,115,884.00	562,583.00
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	28,338,745.40	23,705,883.66
1.2.9	Бусад мөнгөн зарлага	161,885,999.87	99,469,327.06
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(52,642,726.31)	195,927,002.69
2	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
2.1	Мөнгөн орлогын дүн	213,628.72	-
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	213,628.72	-
2.2	Мөнгөн зарлагын дүн	4,317,900.00	19,218,500.00
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	4,317,900.00	19,218,500.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(4,104,271.28)	(19,218,500.00)
3	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
3.1	Мөнгөн орлогын дүн	97,358,432.85	21,900,000.00
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	97,358,432.85	21,900,000.00
3.2	Мөнгөн зарлагын дүн	105,862,500.00	24,222,190.00
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	97,352,500.00	21,900,000.00
3.2.4	Төлсөн ногдол ашиг	8,510,000.00	2,322,190.00
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(8,504,067.15)	(2,322,190.00)
4	Валютын ханшийн зөрүү	-	(1,049.47)
4.1	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(65,251,064.74)	174,387,362.16
5	МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	71,391,847.44	6,140,782.70
6	МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ	6,140,782.70	180,528,144.86

2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2020 оны гүйцэтгэл	2021 оны			
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Нийт орлого	мян/төг	553,679.9	578,124.0	424,785.4	(153,338.6)	26.5
2	Нийт зардал	мян/төг	529,192.1	551,378.4	605,551.9	54,173.5	9.8
3	Татвар төлөхийн өмнөх ашиг	мян/төг	24.487,8	26,745.6	(180,766.6)	(207,512.2)	776.8
4	Хөрөнгө оруулалт	мян/төг	45,000.0	25,000.0	16,000.0	(9,000.0)	36.0
5	Төрийн өмчийн ногдол ашигт	мян/төг	8,510.0	1,860.2	2,322.2	462.0	24,8
6	Ажилчдын тоо	хүн	50	45	44	(1)	2.2
7	Нийт цалингийн сан	мян/төг	282,844.0	273,542.5	233,002.8	(40,539.7)	14.8

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Цагаан шонхор ТӨААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд компанийн дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдолтой холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг 2022 оны 02 дугаар сарын 15-наас 2022 оны 03 дугаар сарын 15-ны хооронд Б энд С аудит ХХК-ийн ахлах аудитор Д.Дашхорлоо, аудитор Э.Дэлгэрцэцэг нар гүйцэтгэж, чанарын хяналтыг менежер Ц.Жамъянхорол хэрэгжүүлсэн.

Цагаан шонхор ТӨААТҮГ нь 2021 оны санхүүгийн тайланг Б энд С аудит ХХК-д 2022 оны 2 дугаар сарын 15-ны өдрийн 31 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Дотоод хяналт

Компанийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна гэж үзсэн.

Тус компанийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитороос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн аудитын зорилго оршино.

Цагаан шонхор ТӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардал 776.1 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 7.8 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4. Санхүүгийн тайлангийн тодруулга

4.1 Байгууллагын үйл ажиллагаа

Цагаан шонхор ТӨААТҮГ-ын зорилго нь Хууль зүй дотоод хэргийн яамны харьяа болон бусад байгууллагуудын хэрэгцээт дүрэмт хувцас, хэрэглэлийг тэдний эрэлт хэрэгцээнд нийцэхүйц чанар стандартын өндөр түвшинд үйлдвэрлэн нийлүүлж, тасралтгүй үйл ажиллагааг ханган Монгол улсын эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулахад оршино гэж тодорхойлсон байна.

Компанийн дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг

- Үйлдвэрийн газрын санхүү, эдийн засгийн чадамжийг дээшлүүлэх хөрөнгийн эх үүсвэр бүрдүүлэх зорилгоор хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын харьяа агентлаг байгууллагуудын албан хаагчдад зориулалтын стандарт бүхий хувцас хэрэглэлээр хангаж үйлчлэх;
- Захиалагчийн захиалгын дагуу чанар стандартын шаардлага хангасан хувцас, хэрэглэлийг оёж бэлтгэн нийлүүлэх;
- Ажил үйлчилгээг чанарын өндөр түвшинд гүйцэтгэх үүднээс техник технологийн дэвшил нэвтрүүлэх;
- Үйлдвэрлэл явуулах чиглэлээр улсын төсөв гадаадын зээл тусламжийн болон хувийн хэвшлийн хөрөнгөөр гүйцэтгэх төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг зохион байгуулах;
- Шаардлагатай нөхцөлд захиалгат бараа бүтээгдэхүүний загвар технологийг боловсруулах;
- Олон улсын болон бусад ижил төрлийн байгууллагатай оёдлын үйлдвэрлэлийн чиглэлээр хамтран ажиллах;
- Оёдлын үйлдвэрлэлийн чиглэлээр гадаад дотоод худалдаа эрхлэх;
- Өөрийн үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүн борлуулах нэрийн дэлгүүрийг зохих журмын дагуу ажиллуулах;
- Хууль тогтоомжоор зөвшөөрөгдсөн бусад үйл ажиллагаа гэж тодорхойлжээ.

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд өрийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын статустай байна. Өмчийн 100 хувь төрийн өмч буюу ХЗДХЯ эзэмшиж байна.

4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин

Цагаан шонхор ТӨААТҮГ нь 1992 оны 168 дугаар тушаалыг үндэслэн байгуулагдсан бөгөөд 2021 оны 5 дугаар сарын 5-ны өдрийн 126 дугаар тогтоолын дагуу удирдлага, эд хөрөнгийн талаарх бүрэн эрхийг ХЗДХЯ-д шилжүүлсэн байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд “Засгийн газар нь төрийн өмчийн бүрэн бүтэн байдлыг Улсын Их Хурлын өмнө хариуцах бөгөөд энэ талаар дараах бүрэн эрхтэй: ... 5/ хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өмчит хуулийн этгээдийг байгуулах, өөрчлөх, татан буулгах тухай шийдвэр гаргах, түүний дүрмийг батлах;...” гэсэн заалттай нийцэж байна.

Монгол Улсын Засгийн газрын “2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.4.10-т “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглалыг олон улсын жишигт нийцүүлэх, газрын хууль тогтоомжийг төрийн байгууламж нэгдмэл байх зарчим болон өмчийн эрх зүйд нийцүүлэн боловсронгуй болгоно.” гэж заасан байна. Энэ хүрээнд ХЗДХЯ-ны харьяанд шилжүүлэх арга хэмжээ авсан байна.

АХГ-2022/79/НА-СТА-ТӨА

Засгийн газрын 2021 оны 43 дугаар “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” тогтоолын 1.3-т заасны дагуу ХЗДХЯ-ны шийдвэрийн дагуу компанийн дүрэм шинэчлэгдэж дотоод зохион байгуулалтын бүтцийг өөрчилж, чиг үүргийн давхардлыг арилгаж орон тоог 3 нэгжээр бууруулан, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан ХЗДХЯ-аас 2.2 сая төгрөгөөр тогтоосон байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- ЗГ-ын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”;

4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

Цагаан шонхор ТӨААТҮГ-ын тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	6,140.8	180,528.1	174,387.3
БХХО	-	-	-
Авлага	40,762.0	34,750.0	(6,012.0)
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	210,615.9	48,601.8	(162,014.1)
Үндсэн хөрөнгө	270,814.9	250,242.6	(20,572.3)
Биет бус хөрөнгө	77,460.9	77,392.2	(68.8)
Нийт хөрөнгийн дүн	605,794.4	591,514.6	(14,279.8)
Өр төлбөрийн дүн	40,118.1	208,927.1	168,809.0
Богино хугацаат өглөг	40,118.1	208,927.1	168,809.0
Урт хугацаат өглөг	-	-	-
Эздийн өмч	565,676.4	382,587.6	(183,088.8)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	605,794.4	591,514.7	(14,279.7)

Касс дахь бэлэн мөнгө 1.0 сая төгрөг, банк дахь харилцах дансанд 179.5 сая төгрөг байна.

Авлагын үлдэгдэлд тайлант онд байгууллагын бараа бэлтгэн нийлүүлэх гэрээний гүйцэтгэлийн баталгаа болох Хаан банкнаас авах авлага 34.7 сая төгрөгийн хугацаандаа байгаа авлага байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 48.6 сая төгрөг болж 162.0 сая төгрөгөөр буурсан нь он дамнан хийгдсэн ажлын дуусаагүй үйлдвэрлэлээс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө худалдан авсан 18.1 сая төгрөгийн хөрөнгөөр нэмэгдэж, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2021 оны А-1/2244 дүгээр албан бичгийн дагуу акталсан 6.7 сая төгрөгийн хөрөнгийн дүнгээр хасагдсан байна.

Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэлд 2021 онд үүссэн 208.5 сая төгрөгийн өглөг бүртгэлтэй бөгөөд ЦЕГ-тай 01/2021-УЗ/114 тоот гэрээний дагуу байгуулсан гэрээний урьдчилгаа 30% буюу урьдчилж орсон орлого байна.

Шалгагдагч байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт үйлдвэрлэлийн өртөг болон удирдлагын зардлын хүлээн зөвшөөрөлт ба үнэлгээг НББОУС-2 Бараа материал бүлэгт тусгагдсаны дагуу хүлээн зөвшөөрч тусгахаар заасан байна.

Санхүүгийн тайланд зардал өртгийн талаарх мэдээллийг бэлтгэх зорилгын дагуу үйлдвэрлэсэн болон борлуулсан бүтээгдэхүүний өртөг, үйл ажиллагааны зардал, үйл ажиллагааны бус зардал гэж ангилсан байна.

Үйлдвэрлэсэн болон борлуулсан бүтээгдэхүүний өртөгт үндсэн үйлдвэрлэлийн шууд хөдөлмөр, үйлдвэрлэлийн нэмэгдэл зардлуудыг шингээсэн байна.

4.4. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу ТӨБЗГ-аар байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

ТӨБЗГ-ын 2020 оны 12 дугаар сарын 08-ны 640 дугаар тогтоолоор Цагаан шонхор ТӨААТҮГ-ын 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна. Тайлант оны нийт орлогыг 578.1 сая төгрөгөөр, нийт зардлыг 551.3 сая төгрөгөөр, ашгийг 26.8 сая төгрөг байхаар төлөвлөсөн байна. Нийт зардлын төлөвлөгөөнд хөрөнгө оруулалтын арга хэмжээнд зарцуулах 25.0 сая төгрөгийг тусгасан байна.

Гүйцэтгэлээр 424.8 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 605.6 сая төгрөгийн зардал гарган, 180.8 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 424.8 сая төгрөг болж төлөвлөснөөс 153.3 сая төгрөг буюу 26.5 хувиар тасарсан нь Ковид цар тахлаас шалтгаалан гэрээний үндсэн нөхцөл болох түүхий эд материалын нийлүүлэлт хийгдээгүй нь голлон нөлөөлсөн байна.

Нийт зардлын гүйцэтгэл 605.5 сая төгрөг болж, төлөвлөснөөс 54.2 сая төгрөг буюу 9.8 хувиар илүү гүйцэтгэлтэй байна. Энэ нь Ковид цар тахалтай холбоотой үүссэн хөл хорио, хязгаарлалтаас үүдэн он дамнан хийгдсэн гэрээт ажил, мөн түүхий эд материалын үнийн өсөлт зэрэг гол нөлөө үзүүлсэн байна.

Тайлант онд алдагдал 180.7 сая төгрөг болж, төлөвлөснөөс 207.5 сая төгрөгөөр өссөн нь он дамнасан гэрээт ажил болон хил гааль хаагдсанаас үүдэлтэй түүхий эд материалын үнийн өсөлт нөлөөлжээ.

ТӨБЗГ-ын 2021 оны 09 дугаар сарын 15-ны өдрийн А-1/1474 тоот шийдвэрийн дагуу 2020 оны ашгийн 10 хувь буюу 2.3 сая төгрөгийн ногдол ашгийг ТӨБЗГ-т төвлөрүүлсэн байна.

5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

5.1 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

АХГ-2022/79/НА-СТА-ТӨА

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст тайлант онд нийт 578.1 сая төгрөгийн 148 мэдээллийг ил тод байршуулахаас 16 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

Байгууллагын бизнес төлөвлөгөө боловсруулах, хүлээн авалт, бэлэг дурсгал, шагнал урамшууллын зардалд 3.6 сая төгрөгийг зарцуулсан байна. Энэ нь МУ-ын ЗГ-ын 2021 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн 43 дугаар тогтоолоор баталсан "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" тогтоолын 1.3 дахь заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

Санхүүгийн тайланд тусгагдсан өмчийн дүн Улсын бүртгэлийн гэрчилгээ болон шинээр батлагдсан байгууллагын дүрэмд тусгагдсан дүрмийн сангаас зөрүүтэй илэрхийлэгдсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.4 "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна" заалттай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг хугацаанд нь байршуулаагүй нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх Засгийн газрын тогтоолын заалтыг хэрэгжүүлээгүй нь бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийн холбогдох шалгуурт нийцээгүй байна гэж дүгнэлээ.

6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Завсрын аудитаар 256.2 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлж, аудитын явцад 185.4 сая төгрөгийг зөрчлийг арилгасан, 70.8 сая төгрөгийн алдаа, зөрчил арилаагүй тул жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитын илрүүлэлтэд тусгасан.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 0.1 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт, 0.8 сая төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүлж, 2.1 сая төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өгснөөс акт 100.0 хувь, албан шаардлага 67.0 хувь, зөвлөмж 50.0 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 2. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		/мянган төгрөг/ Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	1	151.6	1	151.6			
Албан шаардлага	3	796.0	2	796.0	1	-	33.0
Зөвлөмж	2	2,088.9	1	2,088.9	1	-	50.0
Нийт дүн	6	3,036.5	4	3,036.5	2	-	

Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангах болон элэгдлээ бүрэн нөхсөн үндсэн хөрөнгийг дахин үнэлүүлэх, данс бүртгэлээс хасах зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байна.

АХГ-2022/79/НА-СТА-ТӨА

7. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 3.5 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 1.1 сая төгрөгийн алдааг залруулж, 2.4 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 1 албан шаардлага хүргүүлсэн.

Залруулагдаагүй 3.5 сая төгрөгийн алдаа зөрчил нь тогтоосон 7.7 сая төгрөгийн материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул “Зөрчилгүй” дүгнэлт өглөө.

7.1 Залруулсан алдаа

Үндсэн хөрөнгийн дансанд бараа материалын шинжтэй 1.1 сая төгрөгийн байгууллагын гадна хаяг, логог бүртгэж элэгдэл байгуулсан нь НББОУС 16-ын Т-6 “үндсэн хөрөнгө нэмж авах зарим хэсгийг орлуулах болон үйлчилгээний зардал нь үндсэн хөрөнгийн өртгийг бүрдүүлнэ”, Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалын 10-д “Үндсэн хөрөнгө 1-ээс дээш тайлант хугацаанд үйлдвэрлэл, борлуулалт, үйлчилгээ бусдад түрээслүүлэх, эсвэл захиргааны зориулалтаар ашиглаж байгаа биет хөрөнгө үндсэн хөрөнгөнд хамаарна”, гэсэн заалтай тус тус нийцээгүй байна.

7.2 Төлбөрийн акт

Шатахууны зарцуулалтыг хянахад 100 км гүйлтэд зарцуулах шатахууны нормыг 2.4 сая төгрөгийг хэтрүүлэн зарцуулсан нь Зам тээвэр хөгжлийн сайдын 2019 оны 390 тоот “Жишиг норм батлах тухай” тушаалын 1 дүгээр хавсралтаар “Автомашин 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг норм”-ыг баримтлаагүй байна

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох.

7.3 Албан шаардлага

Үндсэн хөрөнгийн дансанд элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн хөрөнгийг дахин үнэлэх, данс бүртгэлээс хасах асуудлыг холбогдох байгууллагад хандаж шийдвэрлүүлээгүй, мөн өмнөх аудитаар зөвлөмж өгсөн боловч хэрэгжилт хангалтгүй байна. Энэ нь НББОУС-16 Үндсэн хөрөнгөд заасны дагуу үндсэн хөрөнгийг анхны удаа өртгөөр нь, дараагийн тайлант үед өртгийн загвар эсхүл дахин үнэлгээний загварын аль нэгийг ашиглан бүртгэнэ, ТӨБЗГ-ын 2019 оны 271 тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 7.1-д “Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ.” гэж заасантай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

8. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаардлага өгсөн зөвлөмжийн утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс									
							Залруулга		Акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж	
					Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн асуудлаар																
1	Цагаан шонхор ТӨААТҮГ	АХГ-2022/79/НА-СТА-ТӨА	Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлэй элэгдэлээрээ анхны өртгөө нөхсөн 35 ширхэг хөрөнгийг дахин үнэлэх буюу холбогдох байгууллагад хандаж, шийдвэрлүүлээгүй асуудлыг өмнөх аудитаар зөвлөмж өгсөн нь хэрэгжээгүй байна.	Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгийг дахин үнэлүүлэх, данс бүртгэлээс хасах саналаа бэлтгэж ТӨБЗГ-т хандаж шийдвэрлүүлэх албан шаардлага өгөх	1						1					
2	Цагаан шонхор ТӨААТҮГ	АХГ-2022/79/НА-СТА-ТӨА	Байгууллагад бүртгэлтэй хоёр автомашины шатахууны тайланг хянахад шатахууны 100 км гүйлтэд зарцуулах норм хэтрүүлсэн байна	Төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоох	1	2,418.9			1	2,418.9						
3	Цагаан шонхор ТӨААТҮГ	АХГ-2022/79/НА-СТА-ТӨА	Шинэчилсэн хаяг лого самбарыг үндсэн хөрөнгөөр бүртгэж элэгдэл байгуулсаныг залруулж хангамжийн материалаар бүртгэв	Үндсэн хөрөнгийн тодорхойлолт нийцэхгүй байгаа тул хангамжийн материалаар бүртгэх залруулга хийх	1	1,098.7	1	1,098.7								
ДҮН					3	3,517.6	1	1,098.7	1	2,418.9	1					
Санхүүгийн тайлангийн асуудлаар шалгасан нийцлийн асуудал																
1	Цагаан шонхор ТӨААТҮГ	АХГ-2022/79/НА-СТА-ТӨА	Шилэн дансны цахим хуудсанд 16 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, өмнөх оны аудитаар зөрчил арилгах албан шаардлагын биелэлтийг хангаагүй, зөрчил давтагдан гарсан байна.	Холбогдох ажилтанд албан шаардлага өгөх	1	578,124.0					1	578,124.0				
2	Цагаан шонхор ТӨААТҮГ	АХГ-2022/79/НА-СТА-ТӨА	Улсын бүртгэлийн гэрчилгээ болон санхүүгийн тайланд тусгагдсан дүрмийн сан	Дүрмийн сангийн дүнг улсын бүртгэлийн гэрчилгээ болон Компаний дүрэмд ижил	1	59,469.1					1	59,469.1				

			зөрүүтэй илэрхийлэгдсэн байна.	дүнгээр баталгаажуулах албан шаардлага өгөх											
3	Цагаан шонхор ТӨААТҮГ	АХГ-2022/79/НА-СТА-ТӨА	Байгууллагын бизнес төлөвлөгөө боловсруулах, хүлээн авалт хийх, бэлэг дурсгалийн зүйлс бэлтгэхэд зардал гаргаж ЗГ-ын 43 дугаар тогтоолыг мөрдөж ажиллаагүй байна	Төсвийг хэмнэлттэй, үр ашигтай байхаар төлөвлөж, зарцуулах албан шаардлага өгөх	1	3,563.8					1	3,563.8			
5	ДҮН				3	641,156.6					3	641,156.6			
НИЙТ ДҮН					6	644,674.2	1	1,098.7	1	2,418.9	4	641,156.6			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2022 оны 03 дугаар сарын 15 № 81/А.О.150053
АХГ-2022/49/НА-СТА-ТӨА

Улаанбаатар хот

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.8-д заасны дагуу Цагаан шонхор ТӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Цагаан шонхор ТӨААТҮГ-т бүртгэлтэй хоёр автомашины шатахууны тайланг хянахад 100 км гүйлтэд зарцуулах автомашины шатахуун зарцуулалтын жишиг нормыг 2,418,911.71 төгрөгөөр хэтрүүлсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.6 "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", Зам тээвэр хөгжлийн сайдын 2019 оны 390 тоот тушаалын 1 дүгээр хавсралт "Автомашины 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг норм"-ыг баримталж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.-д заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Шатахуун зарцуулалтын жишиг норм хэтрүүлсэн 2,418,911.71 /хоёр сая дөрвөн зуун арван найман мянга есөн зуун арван нэгэн мянга далан нэгэн/ төгрөгийг буруутай албан тушаалтнаар төлүүлж, Үндэсний аудитын газрын Төрийн сан банкна дахь Аудитын шалгалтын орлогын 10090000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Цагаан шонхор ТӨААТҮГ-ын дарга Н.Мөнх-Оргил, ерөнхий нягтлан бодогч Ц.Цэнгэлмаа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЕРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР

ГҮЙЦЭТГЭГЧ БАЙГУУЛЛАГА:

Б ЭНД С АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Ц.ХОСЖАРГАЛ

Д.ДАШХОРЛОО

4006109
0010120006

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-261230

\\10.10.10.20\Bichig_Khereg\Alban Shaardloga\2022\0315 Auditin 2 Gazar-73.Docx

001030025



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15 № 415/А0150055
АХГ-2022/49/НБ-СА-70А

Улаанбаатар хот

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд, Төсвийн тухай хуулийн 8.9.8-д заасны дагуу хийсэн Цагаан шонхор ТӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Улсын бүртгэлийн гэрчилгээ болон санхүүгийн тайланд тусгасан дүрмийн сан 59,469,098.00 төгрөгийн зөрүүтэй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Санхүүгийн тайланд тусгасан, өмнөх аудитын тайлангаар баталгаажсан дүрмийн сангийн дүнг компанийн дүрэм болон улсын бүртгэлийн гэрчилгээн дээр зөрүүгүй болгох, дээрх зөрчлийг арилган албан шаардлагын биелэлтийг 2022 оны 9 дугаар сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гарахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Цагаан шонхор ТӨААТҮГ-ын дарга Н.Мөнх-Оргил, ерөнхий нягтлан бодогч Ц.Цэнгэлмаа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР
ГҮЙЦЭТГЭГЧ БАЙГУУЛЛАГА:

Б ЭНД С АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Ц.ХОСЖАРГАЛ

Ц.ДАШХОРЛОО

9006109
9014120196

Монгол Улс Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-204230

\\10.10.10.20\Bichig_Khereg\Alban Shaardlaga\2022\0315 Auditin 2 Газар-73.Docx

0010801129



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15 № 444/АДИ50055
АХГ-2022/79/НА-СА-ТӨА

Улаанбаатар хот

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.8-д заасны дагуу хийсэн Цагаан шонхор ТӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Байгууллагын бизнес төлөвлөгөө боловсруулах, хүлээн авалт хийх, бэлэг дурсгалын зүйлс бэлтгэхэд 3,563,780.00 төгрөгийн зардал гаргасан байна.

Энэ нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.3 "Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх" гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолыг хэрэгжүүлж, зардлыг хэмнэж ажиллах, зайлшгүй шаардлагатайгаас бусад зардал гаргахгүй байхад анхаарах, дээрх зөрчлийг арилган, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гарахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Цагаан шонхор ТӨААТҮГ-ын дарга Н.Мөнх-Оргил, ерөнхий нягтлан бодогч Ц.Цэнгэлмаа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР

ГҮЙЦЭТГЭГЧ БАЙГУУЛЛАГА:

Б ЭНД С АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц НАРАНЧИМЭГ
Ц ХОСЖАРГАЛ

Ц ДАШХОРЛОО

Монгол Улс Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-204230

\\10.10.10.20\Bichig_Khereg\Alban-Shaardlaga\2022\0315 Auditin 2 Газар-74.Docx

0010801131



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15 № 413/АД/50055
АХГ-2022/79/НА-СА-ТӨА

Улаанбаатар хот

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.8-д заасны дагуу Цагаан шонхор ТӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Үндсэн хөрөнгийн дансанд 35 нэр төрлийн 41,724,040.00 төгрөгийн тавилга эд хогшил, машин тоног төхөөрөмж, 28,000,000.00 төгрөгийн суудлын автомашин зэрэг элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн хөрөнгийг дахин үнэлэх, данс бүртгэлээс хасах асуудлыг шийдвэрлээгүй, мөн өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг хангаагүй байна.

Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 20.3 "Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн хүрээнд хэрэгжүүлсэн ажил, түүний үр дүнг төрийн аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд мэдэгдэнэ", НББОУС-16 Үндсэн хөрөнгөд заасны дагуу үндсэн хөрөнгийг анхны удаа өртгөөр нь, дараагийн тайлант үед өртгийн загвар эсхүл дахин үнэлгээний загварын аль нэгийг ашиглан бүртгэнэ, ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 7.1-д "Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн хөрөнгийг дахин үнэлэх, данс бүртгэлээс хасах асуудлыг холбогдох байгууллагад хандаж шийдвэрлүүлэх, дээрх зөрчлийг арилган албан шаардлагын биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гарахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Цагаан шонхор ТӨААТҮГ-ын дарга Н.Мөнх-Оргил, ерөнхий нягтлан бодогч Ц.Цэнгэлмаа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ГҮЙЦЭТГЭГЧ БАЙГУУЛЛАГА:
Б ЭНД С АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Ц.ХОСЖАРГАЛ

Д.ДАШХОРЛОО

4006109

9019110396

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

\\10.10.20\Bichig_Khereg\Alban Shaardlaga\2022\0315 Auditin 2 Gazar-72.Docx

0010801127



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15 № 400/А0150055
АХГ-2022/79/НА-СТА-ТӨА

Улаанбаатар хот

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.8-д заасны дагуу Цагаан шонхор ТӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансны цахим хуудсанд 148 мэдээлэл байршуулахаас 16 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ", 6.4 "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", 6.2.4 "хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, концессын зүйлийн жагсаалт", 6.5.4 "улсын төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбарыг улирал бүр", 6.4.7 "байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт" гэж заасныг тус тус хэрэгжүүлээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж, мэдээллийн ил тод байдлыг ханган, мэдээллийг тогтоосон хугацаанд тогтмол байршуулах, дээрх зөрчлийг арилган албан шаардлагын биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх,
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гарахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Цагаан шонхор ТӨААТҮГ-ын дарга Н.Мөнх-Оргил, ерөнхий нягтлан бодогч Ц.Цэнгэлмаа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ГҮЙЦЭТГЭГЧ БАЙГУУЛЛАГА:
Б ЭНДС АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Ц.ХОСЖАРГАЛ
Ц.ДАШХОРЛОО

9006109
9019120196